

**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ ЭГҮҮЛЭН ТАТАХ ЖУРМЫН ТӨСӨЛД НИЙСЛЭЛИЙН
ИТХ-ИЙН ТӨЛӨӨЛӨГЧДӨӨС ИРҮҮЛСЭН САНАЛ ТОВЬЁОГ**

№	Журмын төслийн заалт	Өөрчлөн найруулах санал	хасах	тайлбар
1	7.1.2 Хууль, тухайн Хурлын шийдвэрийг зөрчсөн;	Тухайн Хурлын шийдвэрийг зөрчсөн;		Тухайлсан салбарын хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргасан тохиолдолд тухайн хуулиараа эсхүл өөр хуульд зааснаар арга хэмжээ авна.
2	7.1.4 Хурлын төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг удаа дараа, ноцтой зөрчсөн		Хасах саналтай	Шинэчлэгдэн батлагдсан ЗЗНДНТУТХ-ийн 41.1.7. дахь заалтаар зохицуулсан
3	12.1 Тухайн тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа, Монгол Улсын сонгуулийн насны иргэн Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачлах эрхтэй.	Тухайн тойргийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа, Монгол Улсын сонгуулийн насны иргэд Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг санаачлах эрхтэй.		Монгол Улсын Үндсэн хууль болон ЗЗНДНТУТХ-д заасны дагуу НӨУ байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй хэвийн явуулах боломж алдагдана
4	12.2 Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг Монгол Улсын иргэн хамтын санал гарган санаачилна.	Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах асуудлыг Монгол Улсын иргэд хамтын санал гарган санаачилна.		
5	15.2 Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг товлон зарлахад тухайн Хурлын төлөөлөгчийн сонгогдсон тойргийн нийт сонгогчдын хоёр хувиас багагүй тооны гарын үсэг цуглуулсан байвал зохино.	Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах санал хураалтыг товлон зарлахад тухайн Хурлын төлөөлөгчийн сонгогдсон тойргийн нийт сонгогчдын \гуравны хоёроос\ багагүй тооны гарын үсэг цуглуулсан байвал зохино.		Сонгогчдын гарын үсэг цугцуулах хэмжээг хэт доогуур болгосоноос улс төрийн зорилгоор ашиглах боломж бүрдэнэ.

6	15.5 Хурал уг гарын үсгийн нэгтгэлийг хүлээн аваад ажлын 5 өдөрт багтаан нийт гарын үсгийн тал хувиас доошгүйг санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэн шалгах ба тухайн иргэнтэй уулзан нягтлан шалгаж болно.	<u>Ажлын 10 өдөрт</u> гэх		Энэхүү журмын 15.2-т сонгогчдын гарын үсэг цуглуулах хувийг нэмсэн учраас иргэдийн нэрсийн жагсаалтын тоо нэмэгдэнэ
7	21.2 Санаачлагчдаас энэ журмын 21.1-д заасан үйл ажиллагаа явуулах эрх бүхий төлөөлөгчдийг Санал хураалтын хороо бүртгэж, үнэмлэх олгоно.	Санаачлагчдаас энэ журмын 21.1-д заасан үйл ажиллагаа явуулахдаа <u>бусдын нэр төр, алдар хүндэд халдах, хууль бус үйлдэл, эс үйлдэхүй явуулахыг хориглоно.</u> Эрх бүхий төлөөлөгчдийг Санал хураалтын хороо бүртгэж, үнэмлэх олгоно.		
Уг журмыг хэрэгжүүлэх явцад улс төрийн үйл ажиллагаа зохион байгуулах, олон нийтийг хамарсан жагсаал цуглаан хийх, намуудын хооронд далд хэлбэрийн зохион байгуулалттай арга хэмжээнүүд явагдах зэрэг нөхцөл байдал үүсэх магадлалтай. Мөн зохион байгуулалттайгаар төлөөлөгчийг эгүүлэн татах нөхцөл үүсч болзошгүй юм. Иймээс Төлөөлөгчийг эгүүлэн татах нөхцөлд нэр дэвшүүлсэн нам нь хариуцлага тооцох хэлбэрээр эгүүлэн тооцох асуудлыг хэлэлцэх байдлаар журамд тусгах				

1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийг эгүүлэн татах үндэслэл хэсэгт Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж чадахгүй байгаа гэдгийг юугаар нотлох нь тодорхой биш байгаа тул нэр дэвшүүлсэн намаас нь эгүүлэн татах, хариуцлага тооцох хэлбэрээр тусгах саналтай байна.

2. Иргэдээс санал гаргаж төлөөлөгчийг эгүүлэн татах процесс маш удаан хугацаагаар үргэлжлэх байдлаар журамд тусгагдсан байгаа нь уг журмыг хэрэгжүүлэх явцад улс төрийн үйл ажиллагаа зохион байгуулах, олон нийтийг хамарсан жагсаал цуглаан хийх, намуудын хооронд далд хэлбэрийн зохион байгуулалттай арга хэмжээнүүд явагдах зэрэг нөхцөл байдал үүсэх магадлалтай. Мөн зохион байгуулалттайгаар төлөөлөгчийг

эгүүлэн татах нөхцөл үүсч болзошгүй юм. Ийм учир Төлөөлөгчийг эгүүлэн татах нөхцөлд нэр дэвшүүлсэн нам нь хариуцлага тооцох хэлбэрээр эгүүлэн тооцох асуудлыг хэлэлцэх байдлаар журамд тусгах

3. Тухайн тойргийн сонгогчдын итгэлийг алдсан гэдгийг хэн тогтоохыг тодорхой тусгах.